



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум  
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.18 № 173

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛДАРХААН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Д.ТӨМӨРХҮҮД

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс босоо тогтолцоотой байгууллагын албан хаагч болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчид компьютер тоног төхөөрөмж худалдан авч нөөц сангаас 27,974.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, батлагдсан төсөвтэй сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад улс, аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн байраа ахиулсан гэх үндэслэлээр 10,600.0 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, 54,500.0 мянган төгрөгөөр өмнөх оны санхүүгийн тайланд өглөгт тусгаагүй сумын 100 жилийн ойн өр барагдуулж, нөөц хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 47,756.0 мянган төгрөгийн цахилгаан өргүүлтэй худаг, 153,130.0 мянган төгрөгийн усалгааны систем, хамгаалалтын хашаа, 25 тонны ёмгос, "Адап" төслөөс 180,000.0 мянган төгрөгийн тэжээлийн фондны барилга, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 48,700.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 12,000.0 мянган

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

814502458

төгрөгийн мал тарилгын хашаа, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас багийн Засаг дарга нарт олгосон 17,285.3 мянган төгрөгийн мотоцикл, 11,490.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, "Шинэ хөдөө" төслөөс 189,900.0 мянган төгрөгийн газар тариалангийн тоног төхөөрөмж, 10,000.0 мянган төгрөгийн мал тарилгын хашаа зэрэг хөрөнгө нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

#### **Аудитын гол асуудал**

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчдад болон албан тушаалаасаа чөлөөлөгдсөн албан хаагчид ээлжийн амралтын цалинг олгохдоо амралтын хоногийг илүү тооцож, 3,928.2 мянган төгрөгийг олгосон, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 7,797.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 174,190.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

#### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,970,907.40</b>	<b>90,368,751.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,300,000.00	7,100,000.00
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	4,300,000.00	7,100,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,300,000.00	7,100,000.00
31211	Төрийн сангийн харилцах	4,300,000.00	7,100,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	48,670,907.40	83,288,751.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,526,955.00	6,526,955.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	42,143,952.40	76,761,796.00
35410	Бичиг хэргийн материал	629,180.00	1,117,700.00
35420	Аж ахуйн материал	7,004,470.00	9,710,520.00
35440	Түлш, шатах тослох материал	6,158,803.40	3,051,426.00
35450	Барилгын засварын материал	3,000.00	3,000.00
35470	Бусад хангамжийн материал	28,348,499.00	62,879,150.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>866,683,037.83</b>	<b>1,481,266,383.11</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	866,683,037.83	1,481,266,383.11
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	836,994,337.83	1,392,889,303.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	787,216,946.48	1,014,972,946.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(352,583,734.60)	(406,690,486.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	272,132,696.65	418,617,960.45
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,811,829.92)	(94,663,321.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	392,908,391.00	551,147,691.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(234,206,972.72)	(265,371,962.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,551,016.00	21,282,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,379,352.90)	(8,992,338.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,148,638.00	209,278,943.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,695,915.16)	(47,407,184.18)
39217	Ном	714,455.00	714,455.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	29,688,700.00	88,377,080.00
39301	Программ хангамж	2,602,000.00	2,602,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,134,500.00)	(2,464,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,221,200.00	88,239,580.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>919,653,945.23</b>	<b>1,571,655,134.11</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>36,130.00</b>	<b>1,837,014.83</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	36,130.00	1,837,014.83
<b>413</b>	<b>Өглөг</b>	36,130.00	1,837,014.83
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,140,056.83
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	36,130.00	696,958.00
41361	Байгууллагад төлөх өглөг	36,130.00	696,958.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>919,617,815.23</b>	<b>1,569,818,119.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	919,617,815.23	1,569,818,119.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,989,594.69	448,989,594.69
51101	Өмч. - төрийн	448,989,594.69	448,989,594.69
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	405,870,501.80	1,056,070,805.85
51210	Өмнөх үеийн үр дүн	50,161,792.84	405,870,501.80
51220	Тайлант үеийн үр дүн	355,708,708.96	650,200,304.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,757,718.74	64,757,718.74
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>919,653,945.23</b>	<b>1,571,655,134.11</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>948,349,884.03</b>	<b>1,752,364,320.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>406,918,996.83</b>	<b>747,229,548.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>406,918,996.83</b>	<b>747,229,548.80</b>
120009	Бусад орлого	5,900,000.18	5,200,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	393,018,096.65	739,279,948.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,000,900.00	2,749,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,430,887.20</b>	<b>1,005,134,772.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>20,687,987.20</b>	<b>34,138,772.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33,071,857.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,687,987.20	1,066,915.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>520,742,900.00</b>	<b>970,996,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	520,742,900.00	970,996,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>592,641,175.07</b>	<b>1,102,164,016.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>592,641,175.07</b>	<b>1,102,164,016.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>535,854,558.14</b>	<b>947,721,954.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>311,418,601.80</b>	<b>466,108,375.33</b>
210101	Үндсэн цалин	234,601,597.56	306,570,082.66
210102	Нэмэгдэл	65,854,157.48	146,204,492.67
210104	Урамшуулал	10,962,846.76	6,293,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,174,148.92</b>	<b>72,044,496.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,485,800.00	49,183,596.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,281,548.92	5,715,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,775,100.00	3,360,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	693,800.00	2,355,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,937,900.00	11,430,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,832,943.78</b>	<b>57,392,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,977,366.78	14,439,618.31
210302	Түлш, халаалт	32,855,577.00	42,953,181.69
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,372,816.60</b>	<b>51,993,977.40</b>
210401	Бичиг хэрэг	5,497,420.00	4,481,080.00
210402	Тээвэр, шатахуун	23,348,196.60	42,565,877.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,580,100.00	2,376,170.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,947,100.00	2,570,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,423,550.00</b>	<b>3,815,850.00</b>
210604	Урсгал засвар	3,423,550.00	3,815,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,098,000.00</b>	<b>3,366,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,098,000.00	3,366,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>638,180.00</b>	<b>4,457,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	531,500.00	2,239,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,680.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	45,000.00	-
210807	I азрын төлбөр	-	1,447,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	95,896,317.04	288,543,354.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,168,136.00	136,327,451.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,549,400.00	170,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,178,781.04	152,045,903.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,786,616.93	154,442,062.67
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	14,698,047.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,698,047.50
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	56,786,616.93	139,744,015.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,225,965.81	139,744,015.17
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	560,651.12	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>355,708,708.96</b>	<b>650,200,304.05</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>355,708,708.96</b>	<b>650,200,304.05</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>547,330,887.38</b>	<b>1,010,334,772.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,900,000.18</b>	<b>5,200,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,900,000.18	5,200,000.00
120009	Бусад орлого	5,900,000.18	5,200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,430,887.20</b>	<b>1,005,134,772.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,687,987.20	34,138,772.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33,071,857.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,687,987.20	1,066,915.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	520,742,900.00	970,996,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	520,742,900.00	970,996,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>536,278,167.38</b>	<b>980,185,472.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>536,278,167.38</b>	<b>980,185,472.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>479,491,550.45</b>	<b>825,743,409.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	311,438,591.67	466,108,375.33
210101	Үндсэн цалин	234,621,587.43	306,570,082.66
210102	Нэмэгдэл	65,854,157.48	146,204,492.67
210104	Урамшуулал	10,962,846.76	6,293,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,040,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НДШ</b>	43,361,500.00	70,904,440.00
210201	Тэтгэврийн даатгал	29,485,800.00	48,043,540.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,468,900.00	5,715,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,775,100.00	3,360,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	693,800.00	2,355,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,937,900.00	11,430,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,032,943.78	57,812,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,977,366.78	14,659,618.31
210302	Түлш, халаалт	33,055,577.00	43,153,181.69
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,438,880.00	33,861,927.00
210401	Бичиг хэрэг	5,504,780.00	4,268,500.00
210402	Тээвэр, шатахуун	22,947,000.00	25,093,357.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,870,100.00	2,376,170.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,117,000.00	2,123,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,789,800.00	3,792,800.00

210604	Урсгал засвар	4,789,800.00	3,792,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,098,000.00</b>	<b>3,366,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,098,000.00	3,366,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>726,180.00</b>	<b>4,910,315.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	531,500.00	2,490,715.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,680.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,000.00	202,000.00
210807	Газрын төлбөр	-	1,447,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,605,655.00</b>	<b>184,986,752.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,402,255.00	184,083,452.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,203,400.00	903,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,786,616.93</b>	<b>154,442,062.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>14,698,047.50</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,698,047.50
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>56,786,616.93</b>	<b>139,744,015.17</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,225,965.81	139,744,015.17
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	560,651.12	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>11,052,720.00</b>	<b>30,149,300.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,752,720.00</b>	<b>27,349,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,752,720.00</b>	<b>27,349,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,752,720.00</b>	<b>27,349,300.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,752,720.00	27,349,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,752,720.00)</b>	<b>(27,349,300.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>4,300,000.00</b>	<b>2,800,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>4,300,000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,300,000.00</b>	<b>7,100,000.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,989,594.69	64,757,718.74	50,161,792.84	563,909,106.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,989,594.69	64,757,718.74	50,161,792.84	563,909,106.27
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	355,708,708.96	355,708,708.96
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,989,594.69	64,757,718.74	405,870,501.80	919,617,815.23
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,989,594.69	64,757,718.74	405,870,501.80	919,617,815.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,989,594.69	64,757,718.74	405,870,501.80	919,617,815.23
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	650,200,304.05	650,200,304.05
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,989,594.69	64,757,718.74	1,056,070,805.85	1,569,818,119.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	977,113,000.00	833,651,984.83
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	977,113,000.00	833,651,984.83
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	949,278,100.00	818,953,937.33
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	571,521,400.00	466,108,375.33
210101	Үндсэн цалин	428,106,600.00	306,570,082.66
210102	Нэмэгдэл	136,374,800.00	146,204,492.67
210104	Урамшуулал	-	6,293,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,040,000.00	7,040,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос төлөх НДШ</b>	71,440,200.00	70,904,440.00
210201	Тэтгэврийн даатгал	48,579,300.00	48,043,540.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,715,300.00	5,715,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,360,000.00	3,360,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,355,200.00	2,355,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,430,400.00	11,430,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	57,812,800.00	57,812,800.00
210301	Гэрэл, цахилгаан	14,602,800.00	14,659,618.31
210302	Түлш, халаалт	43,210,000.00	43,153,181.69
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,155,900.00	29,155,570.00
210401	Бичиг хэрэг	4,268,300.00	4,268,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,387,000.00	20,387,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,376,500.00	2,376,170.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,124,100.00	2,123,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,792,800.00	3,792,800.00
210604	Урсгал засвар	3,792,800.00	3,792,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,366,000.00	3,366,000.00
210702	Дотоод албан томилолт	3,366,000.00	3,366,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,636,700.00	3,619,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	202,000.00
210807	Газрын төлбөр	1,447,000.00	1,447,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	208,552,300.00	184,194,352.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	207,648,900.00	183,291,052.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	903,400.00	903,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,834,900.00	14,698,047.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,834,900.00	14,698,047.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,332,900.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502,000.00	14,698,047.50
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	977,113,000.00	831,251,984.83
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	977,113,000.00	831,251,984.83
122005	Улсын төсвөөс санхүүжих	977,113,000.00	831,251,984.83

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,138,772.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,138,772.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,138,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,706,357.00
210402	Тээвэр, шатахуун	4,706,357.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,290,715.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,290,715.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,141,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,141,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,138,772.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,138,772.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,071,857.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,066,915.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэл:**

- Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх

**Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын зорилго:** Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх, сум орон нутгаа хөгжүүлэх гэсэн зорилго зорилт чиг үүргийн хүрээнд ажилладаг байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:**

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын

ажил гүйлгээнд Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 652,001.2 мянган төгрөгөөр буюу 41.5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,300.0	7,100.0	2,800.0
Бараа материал	48,670.9	83,288.8	34,617.9
Үндсэн хөрөнгө	866,683.0	1,481,266.4	614,583.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>919,653.9</b>	<b>1,571,655.1</b>	<b>652,001.2</b>
Өр төлбөр	36.1	1,837.0	1,800.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	919,617.8	1,569,818.1	650,200.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>919,653.9</b>	<b>1,571,655.1</b>	<b>652,001.2</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,300.0 мянган төгрөг, тайлант онд 2,800.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 7,100.0 мянган төгрөг болсон байна. Бараа материалын эхний үлдэгдэл 48,670.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 105,674.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 2,749.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 73,806.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 83,288.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,617.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 27,349.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 739,279.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 23,268.4 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 1,481,266.4

мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 152,045.9 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 650,200.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 756,094.4 мянган төгрөг, нийт зарлагыг 756,094.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, Засаг даргын нөөц хөрөнгийг тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 831,252.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 833,652.0 мянган төгрөг буюу 85.3 хувьтай байна. Энэ нь цалин, бараа үйлчилгээний бусад зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 116,703.2 мянган төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,592.9 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 16,164.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
<b>70106</b>	<b>Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	549,468.8	485,814.7	63,654.1	88.4%
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	190,960.4	151,048.2	39,912.2	79.1%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,200.0	1,200.0	0.00	100.0%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	27,834.9	14,698.0	13,136.9	52.8%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	147,365.7	136,772.8	10,592.9	92.8%
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	60,283.2	44,118.3	16,164.9	73.2%
<b>НИЙТ</b>		<b>977,113.0</b>	<b>833,652.0</b>	<b>143,461.0</b>	<b>85.3%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 34,138.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс 23,715.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зудын эрсдэлтэй сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр, 9,356.9 мянган төгрөгийг бусад дээд шатны байгууллагаас олгож, 1,066.9 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлсэн байна. Гүйцэтгэлээр 34,138.8 мянган төгрөгийг тээвэр шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөгөөр/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Компьютер тоног төхөөрөмж худалдаж авах	18,549.3	18,549.3
2	Шууд гэрээ байгуулах	Тоног төхөөрөмж худалдаж авах	8,800.0	8,800.0
<b>ДҮН</b>			<b>27,349.3</b>	<b>27,349.3</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 03/69 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 592.641.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,889.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.667.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 1,102,164.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,532.5 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,399.3 мянган төгрөгөөр тогтоосон.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 44 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлэхэд тусдаа батлагдсан төсөвтэй сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад улс, аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн байраа ахиулсан гэх үндэслэлээр 10,600.0 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон зөрчил байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж, 27,057.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 351,751.5 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж, 11,635.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,569.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлага, 177,560.7 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх 174,190.8 мянган төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,569.3	1	4,569.3	100%
Албан шаардлага	2	11,635.5	2	11,635.5	100%
Зөвлөмж	3	351,751.5	2	177,560.7	83.3%
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>367,956.3</b>	<b>5</b>	<b>193,765.5</b>	<b>94.4%</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 293,964.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 14,974.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 3,928.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 220,562.6 мянган төгрөгийн мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 54,500.0 мянган төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлээ.

##### **Залруулсан алдаа:**

Тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй, тайлант онд үүссэн 1,140.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, бусад биет бус хөрөнгө буюу дансанд бүртгэлтэй газарт элэгдэл тооцоолсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай нийцэхгүй, толипуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### **5.1 Төлбөрийн акт**

Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчдад болон албан тушаалаасаа чөлөөлөгдсөн албан хаагчид ээлжийн амралтын цалинг олгохдоо хоногийг илүү тооцож, 3,928,155.39 төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

##### **5.2 Албан шаардлага**

Засаг даргын нөөц хөрөнгөөс босоо тогтолцоотой байгууллагын албан хаагч болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчид компьютер тоног төхөөрөмж худалдан авч, нөөц сангаас 27,974.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тусдаа батлагдсан төсөвтэй сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад улс, аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн байраа ахиулсан гэх үндэслэлээр 10,600.0 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон болон үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд 2 албан шаардлага өглөө.

##### **5.3 Зөвлөмж өгөгдөөгүй**

Нийт илрүүлсэн 278,990.8 мянган төгрөгийн зөрчлөөс 174,190.8 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн, 104,800.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу-лаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан ерөнхий журналыг тулгаг- шалгахад тайлент онд үнэ "өлбөргүй ирсэн 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй.	1	10,000.3			1	10,000.3							
Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан ерөнхий журналыг тулгаг- шалгахад бусад, биет бус хөрөнгө буюу денсанд бүртгэлтэй газарт элэгдэл тооцоолсон байна.	1	3,833.7			1	3,833.7							
Тайлант онд үүссэн 1,140.0 мянган тэгрөгийн өглөгийг санхүүгийн- тайланд тусгаагүй.	1	1,140.1	1	1,140.1									
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>14,974.1</b>	<b>1</b>	<b>1,140.1</b>	<b>2</b>	<b>13,834.1</b>							

/Мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах а.тбан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Эзлэгийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчдад болон албан тушаалаасаа чөлөөлөгдсөн албан хаагчид эзлэгийн амралтын цалинг олгохдоо хоногийг илүү тооцож, 3,928.2 мянган тэгрөгийг олгосон байна.	1	3,928.2	1	3,928.2								
Сумын Засаг даргын нөөц хэрэглээс 54,500.0 мянган төгрөгөөр өмнөх сны санхүүгийн тайланд өглөлт тусгаагүйгээр 2023 онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн өр барагдуулсан нь Эрүүгийн тухай хуульд заасан залилангийн, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байна.	1	54,500.0										1 54,500.0

/Мянган төгрөгөөр/

Үүнээс

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	174,190.8	1	174,190.8						
Засаг даргын нөөц хөрөнгөөс босоо тогтолцоотой байгууллагын албан хаагч болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчид компьютер тоног төхөөрөмж худалдан авч, нөөц сангаас 27,974.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тусцаа батлагдсан төсөвтэй сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад улс, аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн байраа ахиулсан гэх үндэслэлээр 10,600.0 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон.	1	38,574.3	1	38,574.3						
Байгууллагын 4 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 2, 10, 12 дугаар сард дутуу тайлагнасан.	1	7,797.5	1	7,797.5						
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>278,990.8</b>	<b>1</b>	<b>3,928.2</b>	<b>3</b>	<b>220,562.6</b>	<b>1</b>	<b>54,500.0</b>		

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Х.БОЛДБААТАР



Огноо: 2025-02-20

**БОЛОВСРУУЛСАН:**

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

Огноо: 2025-02-20